

БАТЛАВ:
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА И.БАТХҮҮ

“BRAIN DRAIN TO BRAIN GAIN” ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХАД
ШААРДЛАГАТАЙ БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА ХИЙХ, ХӨТӨЛБӨРИЙН
ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 04-р сарын 16-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

1	Захиалагч байгууллага	Эдийн засаг, хөгжлийн яам
2	Эрх зүйн үндэслэл	- Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 15.1.20, 24.2.2, 24.2.4, 26.2 дахь заалт
3	Зорилго	- Монгол Улсын Засгийн газар болон хувийн хэвшлийн зүгээс хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хилийн чанадад академик ажил эрхэлж буй эрдэмтэн, судлаачидтай хамтран ажиллах, оюуны урсгалыг эгүүлэн татах замаар оюуны хүч, нөөц боломжийг бүрдүүлэх.
4	Үргэлжлэх хугацаа	- Гэрээ хийгдсэнээс эхлэн календарын 30 хоног
5	Байршил	- Улаанбаатар хот, Монгол улс
6	Гүйцэтгэх ажлын даалгавар	- Урт хугацааны бодлого, салбарын холбогдох хууль, журмууд, өмнө батлагдсан энэ чиглэлийн хөтөлбөр, түүний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн орчныг судлах; - Гадагш урсах тархины урсгалыг зогсоох, эргүүлэн татах олон улсын сайн туршлага, энэ талаар хэрэгжүүлж буй бодлого, хэрэгжилтийг судлах; - Хилийн чанадад академик ажил эрхэлж буй монгол иргэдээс Монгол улстай хамтран ажиллаж буй өнөөгийн байдал, цаашид хамтран ажиллах боломж, хэрэгцээ шаардлагыг судлах; - “Brain drain to Brain Gain” хөтөлбөрийн төслийг боловсруулах; - Ажлын эцсийн болон санхүүгийн тайланг боловсруулан хүргүүлэх.
7	Хүлээгдэж буй үр дүн	- “Brain drain to brain gain” хөтөлбөр боловсруулахад шаардлагатай бодлогын шинжилгээ, судалгаа хийсэн байна. - 2-оос доошгүй хөгжиж буй орон, 2-оос доошгүй хөгжингүй орны төрөөс энэ талаар хэрэгжүүлж буй бодлого, хэрэгжилтийн сайн туршлагыг судалсан байна; - Хилийн чанадад академик ажил эрхэлж буй 10-с доошгүй улсын 30-с доошгүй монгол иргэдээс Монгол улстай хамтран ажиллаж буй өнөөгийн байдал, цаашид хамтран ажиллах боломжийн талаар судалгаа хийсэн байна; - Хийсэн судалгаан дээрээ үндэслэн “Brain drain to Brain Gain” хөтөлбөрийн төслийг боловсруулсан байна.

8	Ажил гүйцэтгэгчид тавигдах шаардлага	- Эрдэм шинжилгээ, судалгаа, бодлогын дүн шинжилгээ хийсэн 5 ба түүнээс дээш жилийн туршлагатай; - Багийн бүрэлдэхүүнд хилийн чанадад 3-аас доошгүй жил академик ажил эрхэлж буй болон эх орондоо эргэн суурьшиж их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж байгаа эрдэмтэн, судлаачийн төлөөлөлтэй байх; - Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль холбоотой
9	Онцгой нөхцөл	- Ажлын ерөнхий зорилго болон хүрээг өөрчлөхгүйгээр харилцан зөвшилцсөний үндсэн дээр энэхүү ажлын даалгаварт өөрчлөлт оруулж болно.

---000---